



**АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН ТАЙЛАН-ЗӨВЛӨМЖ**

**Хаяг:**

**Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын  
Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс  
Нутгийн удирдлагын ордон 412 тоот**



**БОЛОВСРУУЛСАН:**

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргжилтэн:  
Б.ТУЯА**

## АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

2023.06.30

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго,  
үндэслэл, арга зүй**

Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр ханган, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлж, хугацаанд нь чанартай, үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэхэд оршино.

Аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, 2021 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу үнэлж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Нутгийн удирдлагын хөгжлийн хороо болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдаанд танилцуулж хэлэлцүүлсэн болно.

### **Төлөвлөлтийн хувьд**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг үндэслэл болгон аймгийн бодлогын баримт бичгийг боловсруулахдаа Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулсан байна.

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө нь 5 бодлого, 19 зорилтын хүрээнд 188 арга хэмжээгээр төлөвлөгдөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 57 тоот тогтоолоор батлагдсан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтыг үндэслэл болгон Аймаг байгуулагдсан түүхт 100 жилийн ойг

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

угтсан бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөн 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулан  
2023.04.28-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор 41 арга хэмжээ, 2023.06.29-ны өдрийн 80  
дугаар тогтоолоор 47 арга хэмжээг нэмж хэрэгжүүлэхээр баталсан байна.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ**

Аймгийн 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 24 сум, 23  
агентлаг албан байгууллагаас, цахим болон цаасаар мэдээллийг авч нэгтгэн дүгнэж,  
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгээ.

Д/Д	Хэлтэс	Аймгийн 2023 оны хөгжүүлэх жилийн төлөвлөгөө		
		Хэлтэст хамаарах арга хэмжээний тоо	Нийт арга хэмжээнд эзлэх хувь	Хэлтэст хамаарах заалтын хэрэгжилтийн хувь
1	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	10	4.5 %	57.5
2	Хууль, эрх зүйн хэлтэс	6	2.7 %	70.0
3	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс	159	72.3 %	44.2
4	Санхүү, төрийн сангийн хэлтэс	3	1.4 %	33.3
5	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс	3	1.4 %	43.3
6	Нийгмийн бодлогын хэлтэс	34	15.4	65.9
7	Цэргийн штаб	5	2.3 %	94.0

Аймгийн хэмжээнд 2023 онд 39.5 тэрбум төгрөгийн 220 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 72.3 хувь нь ХБТХОХ-ийн чиг үүргийн хүрээний төсөл арга хэмжээ байна. Үүнээс 63.5 хувь буюу 101 төсөл, арга хэмжээг аймаг байгуулагдсан түүхт 100 жилийн ойн баярыг угтсан хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, тохижилтын ажлуудад төлөвлөн хэрэгжүүлж байна.

Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүлэг, үнэлгээгээр нэгтгэн доор харуулав.

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗЭВЛЭМЖ

### АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ:

БОДЛОГО, ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭГЭР				НИЙТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО
	I.ХҮННИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО	II.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	III.ЗАСАГ- ЛАЛЫН БОДЛОГО	IV.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	
Хяналтанд авсан НИЙТ БУЛГИЙН ТОО	1	1	1	1	5
Хяналтанд авсан НИЙТ ЗОРИЛТЫН ТОО	6	5	5	2	19
Хяналтанд авсан НИЙТ ХЭМЖЭЭНИЙ ТОО	38	38	21	16	220
100 %	13	6	5	2	47
90 %	6	1	1	1	19
70 %	6	5	9	1	32
50 %	4	2	2	-	16
30 %	1	15	2	5	48
0 %	8	9	2	7	58
<b>Хэрэгжилтийн дундаж хувь</b>	<b>65.52</b>	<b>41.84</b>	<b>67.71</b>	<b>31.87</b>	<b>49.5</b>

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнийй хэрэгжилтийг журмын 6.2.1, 6.2.2-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын биелэлтийг доорх хүснэгтээр харуулав.

Д/Д	БОДЛОГО	ЗОРИЛТ	АРГА ХЭМЖЭЭ НИЙ ТОО	ХУВЬ
1	ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:	1.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	9	51.1
2		1.2. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, олимпын тувшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлэх	3	73.3
3		1.3. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлэх	9	85.5
4		1.4. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэн, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин, амьдралын чанарыг дээшлүүлэх	10	57.0
5		1.5. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, "Үндэсний бахархал Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлэх	5	62.0
6		1.6. Хэвллэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчлан, иргэдэд түгээх	2	80.0
7	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:	2.1. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрт хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болох	4	42.5
8		2.2. Бэлчээрийн даацаад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлэх	25	45.6
9		2.3. Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	3	30.0
10		2.4. Эрчим хүчиний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангах	2	15.0
11		2.5. Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлэх	4	40.0

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

12	ЗАСАГЛАЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:	3.1. “Цахим Монгол” төрийн шуурхай үйлчилгээ нэврүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх	8	57.5
13		3.2. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгаж, төрийн чиг үүргийн уялдааг ханган, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох	2	15.0
14		3.3. Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангах	3	70.0
15		3.4. Хараат бус шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх	3	70.0
16		3.5. Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэх	5	94.0
17	НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:	4.1. Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгох	10	16.0
18		4.2. Хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах чадавхыг бэхжүүлэх	6	58.3
19	БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:	5.1. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан, бус, орон нутаг, төв суурин газрын төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг оновчтой хийнэ.	107	46.4
НИЙТ			220	49.5

Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангах зорилтын хэрэгжилт 15.0%-тай байгаа нь уг зорилтыг хэрэгжүүлэхээр тусгагдсан 2 төсөл арга хэмжээ нь тухайн зорилтын биелэлтийг бүрэн хангахуйц төлөвлөгдөөгүй байна.

Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгаж, төрийн чиг үүргийн уялдааг ханган, бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгох зорилтын хүрээнд төлөвлөгдсөн 2 арга хэмжээг 3, 4 дүгээр улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тул уг зорилт жилийн эцэст бүрэн хэрэгжих боломжтой.


Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгох зорилтыг хангахаар төлөвлөгдсөн “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ний хүрээнд хийгдэх тарьц суулгац авах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ойжуулалт, хашаажуулалт хийх 3 төсөл арга хэмжээний тендерийг 2-3 удаа зарлаад оролцогч байхгүй, гүйцэтгэгч шалгараагүй зэрэг шалтгаануудаас дээрх зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

Дээрх 3 зорилтоос бусад зорилтуудын хэрэгжилт хангагдаж байгаа бөгөөд аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгагдсан зорилт арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлснээр жилийн эцэст зорилтын биелэлт бүрэн хангагдах боломжтой юм.

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

## ОЛОЛТТОЙ ТАЛ

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагаандаа мөрдөх, гүйцэтгэлийн үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр ЗДТГ-т 2023 оны 6 дугаар сард анх удаа Төрийн мэдээллийн цахим санг нэвтрүүлж, 24 сум, 21 хэлтэс агентлагийг [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим мэдээллийн санд холбож, туршилтаар 2023 оны эхний хагас жилийн тайлан мэдээг цахимаар авч өхөлсэн нь төлөвлөх, тайлagnaх, үнэлэх зэрэг ажлыг боловсронгуй болгож байна.



## НИЙТЛЭГ ДУТАГДЛУУД

Бодлогын баримт бичгийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, тайлagnaх үе шатанд дараах нийтлэг алдаа дутагдлууд гарч байна. Үүнд:

- Төлөвлөлт хийхдээ суурь түвшин, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг бодитоор төлөвлөөгүй

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

- Зорилт арга хэмжээ нь хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэйгээ уялдаагүй, үнэлэх боломжгүй, хугацааг нарийвчлан төлөвлөөгүй
- Хэлтэс хоорондын болон салбар хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцох, боловсруулалт хийх байдал хангалтгүй
- Хэрэгжүүлэх хугацааг тодорхой тусгаагүй / 3, 4 дүгээр улиралд хэрэгжүүлэх ажлуудын хугацааг тодорхой тусгаагүйгээс 0% гэж үнэлэгдэж байгаа нь нийт хэрэгжилтэд нөлөөлж байна. /
- Харьяа хэлтэс, агентлагаас ирүүлсэн мэдээ тайланд боловсруулалт хийж, нягтлан дүгнэж цахимд оруулаагүй
- Зорилт арга хэмжээг ач холбогдол, хэрэгцээ шаардлагаар эрэмбэлээгүй
- Тендер зарлахаас зайлсхийх зорилгоор мөнгөн дунг багасгаж, хэт жижиглэж төлөвлэсэн
- Тооцоо судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын тоо хэмжээгүй арга хэмжээг, тусгахгүй байх /Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч болон удирдах албан тушаалтнууд бодлогын хэлтэс, мэргэжлийн байгууллагын судалгаа, тооцоололгүй арга хэмжээг шууд тусгадаг/

Дээрх нийтлэг дутагдал нь бодлогын баримт бичгийг боловсруулахад зарим арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бодитой тооцож төлөвлөөгүй, цаг хугацааны хувьд нэг жилд хэрэгжүүлэх боломжгүй, тооцоо судалгаа дутуу зорилт, төсөл арга хэмжээ төлөвлөх нь хэрэгжүүлэх, тайлагнах, үнэлэх үе шатуудад хүндрэл учруулж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журам, 2021 оны 374 дүгээр тогтоол, холбогдох журам заавруудыг нарийвчлан судалж мөрдөн ажиллах шаардлагатайг харуулж байна.

### *Гурав. Үнэлгээний дүгнэлт*

Аймаг байгуулагдсан түүхт 100 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын ажлуудыг төлөвлөн 2 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулж батлагдсан арга хэмжээнүүдийг нэн даруй тендер зарлах, харьцуулалтын арга болон шууд гэрээ байгуулах ажлуудыг хуулийн хүрээнд шуурхай зохион байгуулж, шаардлагатай хөрөнгө, санхүүжилтиг шийдвэрлэн, хяналтыг сайжруулснаар гүйцэтгэлийн үр дунг нэмэгдүүлэх боломжтой юм.

Иймд: Эрчимжүүлэх шаардлагатай буюу үр дүнгүй хэрэгжсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлж, төлөвлөгөө гарган, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах шат дараалсан арга хэмжээг авч хэрэгжүүлснээр жилийн эцэст бүрэн хэрэгжих боломжтой гэж дүгнэлээ.

**Дөрөв. Цайшид анхаарах асуудлууд, хэрэгжүүлэх ажлын зөвлөмж**

- Тооцоо судалгаа, ТЭЗҮ, зураг төсөв, ажлын тоо хэмжээгүй төсөл арга хэмжээг, төлөвлөхгүй байх.
- Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явц болон гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах. /ХБТХОХ/
- Хэрэгжилт гаргахад тухайн зорилт, арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын явц буюу процессыг тайлагнах бус гарсан үр дүн, зарцуулсан төсөв санхүүг эх үүсвэрийн хамт үнэн зөв, бодитой тайлагнах. /Журмын 6.8/
- Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт тайлагналтын талаар хэрэгжүүлэгч байгууллагуудыг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, нэгдсэн ойлголттойгоор аймгийн ЗДЗ-д танилцуулж хэвших. /Бүх хэлтэс/
- Бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулахдаа үндэслэлийг нарийвчлан гаргаж ХШҮХ-с саналыг авч оруулах. /Журмын 11.5/
- Зорилт арга хэмжээний хэрэгжилтийг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэйгээ уялдуулан журмын 6.8-д заасны дагуу бодитой тайлагнах талаар харьяа агентлаг, байгууллагууддаа сургалт, мэдээлэл хийх. /Бүх хэлтэс/
- Үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай нь тодорхой болсон зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх талаар холбогдох агентлагуудад чиглэл өгч, төлөвлөгөө гарган ажиллах. /Бүх хэлтэс/
- Хэлтэст хамаарах салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зөв үнэлж, хэрэгжилтийн дундажийг тооцож, бодлогын мэргэжилтний ажлын үнэлгээнд оруулах. /Бүх хэлтэс/
- Батлагдсан тайлан мэдээний жагсаалтад заасан хугацааг мөрдөн ажиллах. /Бүх хэлтэс/

АЙМГИЙН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлагналтын чанарын үнэлгээг хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэг үзүүлэлт болгон оруулах.
- Тухайн дэвшиүүлсэн зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтэд заасан чанарын болон тоон үзүүлэлт тус бүрээр хүрэх түвшинтэй нь харьцуулан гаргаж байх.
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс биелэлттэй холбоотой нэмэлт мэдээлэл, баримт материал шаардсан тохиолдолд холбогдох албан тушаалтнууд тухай бүр нь хурдан шуурхай, үнэн зөв, чанартай гаргаж заасан хугацаанд ирүүлж байх.
- Үнэлгээгээр үр дүнгүй, эрчимжүүлэх шаардлагатай нь тодорхой болсон зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах, эрчимжүүлэх талаар харьяа агентлаг, байгууллагууддаа чиглэл өгч төлөвлөгөө гарган ажиллаж ямар үр дүн гарсан талаарх тайланг 2023 оны 9 дүгээр сарын 28-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс ирүүлнэ үү.

**ТАНИЛЦСАН:**

Аймгийн Засаг даргын Тамгын  
газрын дарга

Г.МЯГМАРСҮРЭН



**ХЯНАСАН:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний  
хэлтсийн дарга

Н.БЯМБАДОРЖ

**ЗӨВЛӨМЖ ГАРГАСАН:**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний  
хэлтсийн мэргэжилтэн

Б.ТУЯА